



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 13 өдөр

Дугаар А/89

Халбан

Хорио цээр тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.7 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйл 18.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Дэлгэрхаан багийн Дэлгэрхаан, Ухаа, Сэнжит, Хар боом, Үзүүрийн мод толгой, Арын мод толгой, Хагийн даваа нэртэй газруудын ойн сангийн 143, 144, 145, 149, 136, 167, 154 зэрэг хэсэглэлүүдийн ойн талбайд яacobсоны төөлүүрч эрвээхэй, өрөөсгөл хур эрвээхэй зэрэг ойн хөнөөлт шавж голомттой тархалт илэрч хортон шавжийн устгал тэмцлийн ажлыг 2024 оны 07 дугаар сарын 13-ний өдрөөс 07 дугаар сарын 27-ны хугацаанд голомт бүхий газар хүн, мал, тэжээвэр амьтан нэвтрүүлэхгүй хорио цээр тогтоосугай.

2.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хорио цээр тогтоосон хугацаанд орчны бүсийн иргэдэд мэдээлж хяналт тавьж ажиллахыг Дэлгэрхаан багийн Засаг дарга (Б.Даваа), Байгаль хамгаалагч (Л.Дамдинсүрэн) нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Бямбажав)-т даалгасугай.

ДАРГА



Н.АНХБАЯР